



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/241

Улаанбаатар хот

“Улаанбаатар кап” волейболын тэмцээнд
баг тамирчдыг оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1503 дугаар захирамжийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Улаанбаатар хотын Ерөнхий боловсролын сургуулиудын дунд зохион байгуулагдах “Улаанбаатар кап” волейболын тэмцээн 2025 оны 11 дүгээр сараас 2026 оны 04 дүгээр сар хүртэл зохион байгуулагдах тул ахлах болон дунд насны ангилалд баг тамирчдыг бэлтгэн оролцуулахыг Биеийн тамир, спортын хороо (Г.Тэмүүлэн)-нд үүрэг болгосугай.

2.Тэмцээнд оролцох эрхийн хураамжид шаардлагатай 1,700.000 (сая долоон зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3.Санхүүгийн тайланг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг Биеийн тамир, спортын хороо (Г.Тэмүүлэн)-нд, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 11... сарын 10... -ны өдрийн 1004/... дугаар
захирамжийн хавсралт



“УЛААНБААТАР КАП” ВОЛЕЙБОЛЫН ТЭМЦЭЭНД
ОРОЛЦОХ ЭРХИЙН ХУРААМЖИЙН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хүний тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
91 дүгээр сургууль				
1	Эрхийн хураамж (Ахлах нас) эрэгтэй, эмэгтэй	2	300,000	600,000
2	Эрхийн хураамж (Дунд нас) эрэгтэй, эмэгтэй	2	200,000	400,000
94 дүгээр сургууль				
3	Эрхийн хураамж (Ахлах нас) эрэгтэй	1	300,000	300,000
4	Эрхийн хураамж (Дунд нас) эрэгтэй, эмэгтэй	2	200,000	400,000
	Нийт			1,700,000

